

СОВРЕМЕННЫЕ АСПЕКТЫ ИССЛЕДОВАНИЯ ЛИТЕРАТУР ТЮРКСКИХ И МОНГОЛЬСКИХ НАРОДОВ

DOI 10.30792/2222-7547.2018.171-181

Баатаржав Мөнхбаяр
Институт языка и литературы Академии наук Монголии
Улан-Батор, Монголия
Bayar_pak @yahoo.com

БУРИАДЫН ЯРУУ НАЙРАГ ДАХЬ СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

Товч агуулга: Ямар ч үндэстэн угсаатан урлагийн бүтээлдээ өөрсдийнхөө үнэт зүйлийг дүрсэлдэг. Ийм үнэт зүйл нь Буриадуудын хувьд Буриад хэл, угсаа гарал, түүх, ардын гүн ухааны мэдлэг нь юм. Эдгээр зүйлсээ өнөөгийн яруу найрагтаа хэрхэн дүрсэлснийг задлан шинжилжээ.

Түлхүүр үг: яруу найраг, соёлын үнэт зүйл, буриад хэл, үндэстэн, гүн ухаан.

Baatarjav Munkhbayar
The Institute for Language and Literature of the Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia

CULTURAL VALUES IN THE BURYAT POETRY

Abstract: In literature of any people its cultural values are reflected. The author considers such values as the Buryat language, origin, history and popular wisdom in modern poetry.

Keywords: poetry, cultural value, Buryat language, nation, philosophy.

Аль нэгэн цаг үед бүтээгдсэн сонгодог сайн бүтээлд тухайн үндэстэн угсаатны туршлага, өв сан, ололт нээлт, хэв маяг, үзэл санаа, сайхны эрмэлзлэл зэрэг соёлын үнэт зүйлс нь шингэсэн байх ажээ. Энэ үүднээс үзвэл: Буриад түмэн өөрсдийн үндэсний оюун санааны үнэт зүйлсийг бүтээн бий болгох үйл явцыг амьдрал, аж төрлийнхөө салшгүй нэгэн хэсэг болгож чадсан байдаг. Тийм болохоор Буриадын ард түмний олон зуун жилийн турш туурвин бүтээж ирсэн урлаг, соёлын үнэт зүйлс нь:

1. Тухайн үндэстнийхээ соёлын үнэт зүйлтэй холбоотой байдаг.
2. Нийт хүн төрөлхтний соёлын үнэт зүйл бүхий бүтээл туурвилтай олон талын шүтэлцээ холбоонд оршиж байдаг.

Энэхүү харилцаа холбоог буриадын яруу найрагт туссан соёлын үнэт зүйлийн жишээн дээр тодруулан авч үзье.

I. Буриад хэл ба Буриадын яруу найраг

Ямар ч үндэстэн угсаатны аж төрөл ахуй орчинд *modernization*¹, *westernization*², *globalization*³ зэрэг соёлын “шинэ” хэв маяг, дэг ёс, үйл ажиллагааны нэвтрэлт, түүний далайц, хүрээулам их идэвхижихийн хэрээр нийгэм, хүмүүнлэгийн салбар дахь *ecology*⁴-ийн асуудал хурцаар яригддаг ажээ. Энэ тухайд эрдэмтэн Ш.Чоймаа: «Ер нь экологи хэмээх ойлголт нь орчин үед унаган төрхийг нь хамгаалах, нөхөн төлжүүлэх хэмээсэн гол агуулгыг илэрхийлж, сав шимийн ертөнц хийгээд оюун санааны ертөнцийн зохист тэнцвэрт орчныг хэвээр нь хадгалах, тийм боломж нөхцөлийг бүрдүүлэх, түүнд харшлах аливаа үйлдэлтэй эрс тэмцэх зэргийг гол зорилгоо болгож байна. Хэрвээ хүн төрөлхтөний оюун санааны ертөнц, түүний өв санг хамгаалах хэмээвээс тулгуур үндэс нь болсон хэлийг хамгаалах ёстой. Мэдээж хэрэг хэл гэдэгт эрт эдүгээгийн олон хэл аялгуу тэдгээр хэл аялгуугаар бүтээсэн аман зохиолын болон бичгийн зохиолын олон зуун жилийн гайхамшигт оюуны баялгийг багтаан хэлж байна» [Чоймаа, 2012] гэж үзсэн байх бол, академич Л. Болд: «Эх хэл бол эх орондоо хэрхэн хайртай, хэрхэн иргэнийнхээ үүргийг биелүүлж байна гэдгийн хэмжүүр юм. Эх хэлээ хөгжүүлж байгаа, улсынхаа аюулгүй байдлыг хамгаалж байгаа улс орнууд бол энэ уриаг бүгд хүлээн зөвшөөрнө гэж би хувьдаа боддог. ... Эх хэл нийгмийг бүхэлд нь хамарч байгаа биз дээ. Эх хэлнээс ангид хүн байна уу. ... Нийгэмд эх хэлний үнэлэмж маш доогуур байна. Энэ нь өнгөцхөн харахад илүүц зүйл юм шиг санагдаж болох ч үүний цаана монгол сэтгэхүй, монгол ахуй, бидний дэлхийгээс дангаарших гэж хүсээд байгаа бүх үнэт зүйл оршиж байгаа юм» [Болд] хэмээн тодорхойлжээ.

Эдгээр үзэл санааны нийтлэг тал “Эх хэл” хэмээх зүйл нь тухайн үндэстэн угсаатныхаа:

¹ Modernization – шинэчлэлийн үйл явц, давалгаа нэвтрэх, шинэчлэл нэвтрэх нутагших үйл явц.

² Westernization – өрнөдийн орнуудын соёлын хэв журам, үнэт зүйлс, технологийг нэвтрүүлэх, дагах, хэвшүүлэх.

³ Globalization – дэлхийн улс орнууд эдийн засаг, санхүү, улс төр, хэл, соёл, техник технологийн салбарын хүрээнд нягтрах үйл явц.

⁴ Ecology – байгаль хүрээлэн байгаа орчны тэнцвэр, аюулгүй байдлын нөхцлийг хангах, хадгалах тухай ойлголт.

1. “Соёлын тусгал болдог”¹
2. “Соёлын нөлөөнд оршиж, бүхий л соёлынх нь тээгч болдог”²
3. “Соёлын бодит баримт болдог”³

гэдгийг илэрхийлсэнд оршино. Өөрөөр хэлбэл “Эх хэл” нь тэр үндэстэн угсаатныхаа “*Үнэт зүйлийн нэгэн илрэл нь болдог*” гэдгийг тодотгожээ. Тийм болохоор олон уран бүтээлчид “Эх хэл”-ээ өөрсдийн бүтээлийнхээ гол дүр болгосон байдаг.

Буриадын олон яруу найрагч эх хэлээ шүлэг найрагтаа мөнхөлжээ. Жишээ нь: Б. Зийдэгмаа “Буряад хэлэн”, Б. Батхүү “Аялгата сайхан буряад хэлэмни”, “Буряад-Монголоой нютаг” Б. Амгалан “Уг изагуурта Буряадайм...” Н. Дашидондок “Буряад хэлэмни хайратай”, Раднаева Санджэ-Сурун (Галина) “Буряадни” зэрэг олон бүтээлийг дурдаж болно.

Б. Зийдэгмаа “Буряад хэлэн” шүлэгтээ ийн өгүүлжээ.

<i>Өөрэйнгээ бэишэн буряад шүлэггөө</i>	<i>Өөрийнхөө бичсэн буриад шүлгээ</i>
<i>Өөрөөл би монгололжсо үзэбэб;</i>	<i>Өөрөө л би монголчилж үзэв</i>
<i>Өөрэймни анханай найхан аялга</i>	<i>Өөрийн минь анхны сайхан аялга</i>
<i>Өөрэл болошоһон шэнги ханагдана.</i>	<i>Өөр л болсон шиг санагдана.</i>

<i>Анханаа би монголоор бэишэнээ</i>	<i>Анхнаасаа би монголоор бичсэнээ</i>
<i>Алдуугүй зохидоор буряадшалжа үзэбэб;</i>	<i>Алдаагүй зохисоор буриадчилж үзэв</i>
<i>Анханай ханаамни хэбээрээл аад,</i>	<i>Анхны санаа минь хэвээр атал</i>
<i>Аялгань харин зохидхон болоһон байба.</i>	<i>Аялга нь харин зохисон болсон байв</i>

[Алтан модоной баяр, 2016, 38-р т.]

хэмээн өгүүлжээ. Энэ бол ерөөсөө эх хэлтэйгээ хүйн холбоотой байгаа төрөлхийн заяамал мөн чанарын тухай дүрсэлсэн хэрэг юм. Уламжлалын талаас нь олон найрагч дурдаж болох ч, Монголын яруу найрагч М. Цэдэндоржийн “Болохгүй юм гэж орчлонд хаана байна” (1966–1967) шүлгийг онцлон дурдаж болно.

Адал орчлонд эрдэнэт биеийг олгосон
Ачит ижсийн цагаан сүүг хор гэхэд би үнэмшихгүй
Ангаахайн чинээ байхаас бүүвэйлсэн үг
Аялгуу сайхан монгол хэлийг хомс гэхэд би итгэхгүй
Эх орон гэдэг үгийн амин сүнс болсон
Ээж, эх хэл хоёроосоо урвана гэж надад үгүй.

[Цэдэндорж, 1988, 169-р т.]

гэсэн энэ мөртэй Б. Зийдэгмаагийн “Буряад хэлэн” шүлгийн үзэл санаа нийцэж байна. Түүнчлэн эл бүтээлд холбогдох өөр нэгэн баримт өгүүлбэ. Монголын нэрт зохиолч Ч. Лодойдамба “Тунгалаг Тамир” романаа бичих үед Монгол Улс кирилл бичигт шилжсэн байсан ч гэсэн зохиолч маань монгол бичгээрээ бичсэн юм. Хожим ёстой л, “*Өөрийнхөө бичсэн Тунгалаг Тамир романаа Лодойдамба гуай өөрөө кирилээр буулгатад Өөрийн минь анхны сайхан аялга Өөр л болсон шиг санагд*”-сан ажээ. Зохиолч энэ тухайгаа Цэдэнбал даргад бичсэн захидалдаа бичсэн байдаг. Ийн үзвэл дээрх баримтуудад эх хэл нь соёлын үнэт зүйл болсныг илрүүлэхийн сацуу **эх хэл – соёл – ардын уламжлал – зан заншил – нийгмийн болон үндэстний бүтэц** зэрэг нь тун нарийн шүтэлцээтэй, харилцан холбоотой ойлголт мөн гэдгийг харуулж байна.

Тэгвэл Б. Батхүү “Аялгата сайхан буряад хэлэмни” шүлэгтээ:

<i>Тэнгэрийн хууляар амилһан</i>	<i>Тэнгэрийн хуулиар амилсан</i>
<i>Аялгата буряад хэлэмни.</i>	<i>Аялгаат буриад хэл минь</i>
<i>Газарай манлайда мүндэлһэн</i>	<i>Газрын манлайд мэндэлсэн</i>
<i>Буряад-монгол хэлэмни.</i>	<i>Буриад Монгол хэл минь</i>

Барга-Баатар хаанай

Барга баатар хааны

¹Хэлийг соёлын шууд тусгал гэж үзэл: Хэл нь бодит ертөнцийн тусгал ба харин соёл бол хүн зайлшгүй тулгарах уг бодит ертөнцийн салшгүй нэгэн хэсэг юм. Бодит ертөнц өөрчлөгдөхөд үндэстний соёлын хэвшмэл ойлголт өөрчлөгддөг ба түүнийг дагаад мөн хэл өөрөө бас өөрчлөгдөнө [Бүтэц хэл шинжлэл. Структурная лингвистика. Ф. де Соссюр. Курс общей лингвистики, 1916. Функциональная стилистика Пражской школы 1926–1953 (В. Матезиус, Я. Мукаржевский, Б. Трнка, Н. С. Трубецкой, Р. О. Якобсон)].

²Хэл нь соёлын нөлөөнд байдаг гэх үзэл: Вильгельм фон Хумбольдтын дэвшүүлсэн 1. Биет ба оюуны соёл нь хэлэнд оршиж, хэлээр амилдаг юм. 2. Ямар ч соёл үндэстний шинжтэй байх ба үндэстний хэл нь өөрийн онцлогийг агуулсан дотоод хэлбэртэй юм. 3. Энэхүү дотоод хэлбэр гэдэг нь ард түмний сэтгэл, сүнс, соёл нь юм. 4. Тиймээс “Хэл гэдэг нь хүнийг өөрийн ертөнцтэй нь холбодог гинжэн холбоос юм” гэх үзэл. Мөн “Хэл бол санаа бодлоо илэрхийлэх багаж төдийгүй хэл нь өөрөө бидний бодлыг бий болгодог ба бид яаж ярина түүн шигээ ертөнцийг хардаг” гэсэн Сепир Уорфын хэл шинжлэлийн таамгийг оруулж болно.

³Хэл бол соёлын бодит баримт гэх үзэл: Энэ үүднээс хэл нь: 1. соёлыг бүрэлдүүлэгч хэсэг, 2. Соёлыг эзэмших үндсэн зэвсэг, 3. соёлын чухал үзэгдэл, 4. бие даасан тэмдэгтийн тогтолцоо болох юм.

*Хүнэнэ эбээһэн буряадни.
Баргажан-Гуа хатанай
Хү шэнгээһэн хэлэмни.*

*Бүртэ буурал абымни
Хүлэгэй дуун бэлэй.
Марал-Гуа эжымни
Үлгын дуун бэлэй.*

[Алтан модоной баяр, 2016, 49-р т.]

гэх зэргээр эх хэлний эрхэм бахархалт шинжийг тодотгохын тулд эртний түүхэн өгүүлэмжтэй холбон өгүүлсэн байна. Эл өгүүлэмжийн гол санаа нь буриадууд ийм баялаг сайхан түүхтэй, бахархах үнэт зүйлтэй, үүгээрээ бахархах, дээдлэх хайрлах хамгийн эхний алхам нь эх хэлээ хайрлах, хамгаалах, хадгалах гэсэн үзэл санаа юм. Тэгвэл “Буряад-Монголоой нютаг” шүлэгтээ:

*Уянгата дуу, хэлэ, соёл хүргэжэ ерэнэн
Утын ута зам харгы – арад зонойм шүтөөн лэ.
Энхэргэн һайхан аба эжын бидэндээ шэнгээһэн
Эртын хургаалтай ёһо заншил – эрхим ехэ шүтөөн.*

[Алтан модоной баяр, 2016, 51-р т.]

*Уянгат дуу, хэл, соёл хүргэж ирсэн
Уртын урт зам харгуй – ард зонын минь шүтээн
Энхэргэн сайхан аав ээжийн минь
бидэндээ шингээсэн
Эртийн сургаалтай ёс заншил – эрхэм их шүтээн*

хэмээн дүрсэлжээ. Хэрэв эхний шүлэгт буриадын ард түмний өөрөөрөө бахархах үнэлэмжийн тухай өгүүлсэн бол “Буряад-Монголоой нютаг” шүлэгт буриадын ард түмний оюун сэтгэлгээний үнэт зүйл нь юу юм бэ? гэдгийг харуулж найрагч энэ асуултдаа буриадын ард түмний “ардын дуу, эх хэл, соёл, ёс заншил зан үйл” хэмээн хариулжээ. Онолын талаас нь үзвэл нийгэмдэхэрхэмчанар (ардын дуу, эх хэл, соёл, ёс заншил зан үйл)-ууд нь зарим үед мөнхийн, түүхийн хөгжлөөс ангид чанартай мэт болдог ч ямар ч үндэстэн угсаатны соёлд эрхэм чанар бий болж, бий болохын хэрээр мөхөж үгүй болдог гэнэ. Эрхэм чанарын агуулга нь нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөгдөж байдаг. Тэгвэл өнөөгийн, орчин цагийн нийгмийн хөгжлийн үед бидний байнга санаж явах ёстой зүйл бол СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ шүү гэдгийг хэлж өгч байна. Тэгвэл Б. Амгалан “Уг изагуурта Буряадайм ...” гэдэг нэгэн шүлэг байна.

*Ага, Хорёор дэлгэрһэн
Аман үгын абдар гэдэг
Арад зоноо суурхуулһан
Аман үгын баялиг –
Алтан мэтэ буряад хэлэн.
Аяар холын Захааминда,
Арадань һуудаг Түнхэндэ
Амалжа хүлэгөө мордоно*

*Ага, Хориор дэлгэрсэн
Аман үгийн авдар гэдэг
Ард зоноо алдаршуулсан
Аман үгийн баялаг –
Алтан мэт Буриад хэл
Алс холын Захааминд
Ард нь суудаг Түнхэндэ
Амалж хүлгээ мордоно*

[Алтан модоной баяр, 2016, 55-р т.]

Энд нэг онцлог байгаа нь эх хэлний урлагийн ид хүч үйлчлэх чанарын тухай онцлон товойлгон дүрсэлжээ. Энэ бол ардын сургаал, аман зохиол, Аламжи мэргэн, Гэсэрийн тууль энэ бүхний бэлгэдэл болсон дүрслэл. Үгийн урлагийн иж бүрэн тогтолцоо, аман уламжлалын нандин баялаг өвөөр дамжиж хүмүүнлэгийн боловсрол, хүн байхын мөн чанарыг хүртэн мэдэрдэг гүн санааг илтгэсэн байна.

Мөн түүнчлэн Надцалов Дашидондокын “Буряад хэлэмни хайратай” шүлгийг онцлон дурдах ёстой. Шүлгийн гол шинж нь буриад хэлэндээ хандаж буй орчин үе, XXI зууны энэ цагийн үнэлэмж, сэрэл мэдэрэмжийг илтгэсэнд оршино.

*Атар хүлэгэй гүйдэлээр
Адлхан сугтаа гэшхэлһэн,
Буурал аба эжым дамжуулһан
Буряад хэлэмни хайратай!*

*Атар хүлэгийн гүйдлээр
Адлхан цугтаа гишгэлсэн
Буурал аав ээжийн минь дамжуулсан
Буриад хэл минь хайртай*

*Шэмэрүүн сагай тулалдаанда
Хашалган, хамалганда ороошье һаа,
Шэдитэ хүсөө харуулһан
Буряад хэлэмни хайратай!*

*Сэмрүүн цагийн тулалдаандаа
Хавчилт, дайралтад ороход ч
Шидэт хүчээ харуулсан
Буриад хэл минь Хайртай*

*Харшин зоной хэлэнтэй
Үзэг бүхэмнай адлиханшье хаа
Халуун шуһан соомни мүнхэрһэн
Бурыад хэлэмни хайратай!*

*Үдэр бүриин ажабайдалда
Олон асуудалай байгаашье хаа,
Үри хүүгэдтээ дамжуулаха
Бурыад хэлэмни хайратай!*

[Алтан модоной баяр, 2016, 136-р т.].

Надцалов Дашидондогийн дүрсэлжээ. Тэрээр хэн ч гэсэн амьдралын хэв маяг, үнэт чанар, хөдөлмөр, үйл ажиллагаа, ахуй амьдрал, амьдралын баяр хөөр, ёс суртахууны хэм хэмжээ зэргээрээ харилцан адилгүй байх нь мэдээж. Гэсэн ч ямарваа үндэстэн угсаатны хувьд соёлын үнэт зүйлийн хандлагууд нь мөнхийн хувиршгүйулмаар түүхийн өмнөх үетэйгээ холбогддог. Харин тэрхүү үнэт зүйлдээ хандах шинэ үнэлэмж, үнэлэлтийн үйл явц байнга өрнөн, хөгжиж өөрчлөгдөж, ахиж дэвших юм уу, багасч буурч байдаг гэдгийг буриад хэлэндээ хандаж буй өнөөгийн хүний сэтгэл зүйгээр илтгэсэнд эл бүтээлийн үнэ цэн оршиж байна.

Одоо эх хэлийг гол дүрээ болгосон өөр нэгэн бүтээлийг үзье. Энэ бол Раднаева Санджэ-Сурун (Галина) “Бурыадни” юм.

*Гольболдоһон хоёр һэлмын
Эри дээрэ тэнсэһэн бар хүсэнини
Гэтэрлүүлһэн эрэ ямаанай
Хүзүүндэ уригдаһан хуби заяантайшни
Ямар хэлэн дээрэ
Ярилдаһан байгаа хаб,
мэдэһэйб, Бурыадни!*

*Галабай сэнхир аласта
Шумуул мэтээр
Үрэхюулэб гээгүй хүсэлини
Шулуу шэнгээр
Үйрэхэһөө айгаагүй найдалтайшни
Дуушанайл хэлэн дээрэ
Дуугаралсаһан байгаа ха,
Тухайлнаб, Бурыадни!*

[Алтан модоной баяр, 2016, 157-р т.].

Эх оронч иргэний зориг ирмүүн уур амьсгал цогцолжээ, эл шүлэгт. Маш уран хурц өгүүлэмжтэй, сэтгэлийн хөдлөлтэй шүлэг болсон байна. “Солбилцож байгаа хоёр сэлэмний хурц ир”-энд үнэхээр “барын хүч”-гаргаж байж л тогтоож үлдэнэ. Чулуу шиг үйрэхээс айлгүйгээр эх хэлээрээ тэмцэнэ гэдэг бол иргэний зориг. Ийм их тэсвэр тэвчээр, сэтгэлийн хат, нугаршгүй чин зориг гаргаж байж оршиж байгаа шүү, бид” гэсэн энэ агуулгаар бахархахгүй байхаас өөр ямар арга алга билээ. Үндэстний мэдрэмж үнэлэмж яруу найргийн уран хурц дүрслэл, өгүүлэмжээр илэрсэн нь энэ юм шүү.

Ийнхүүэх хэлээ гол дүр болгон бүтээсэн буриадын яруу найрагчдын шүлэг бүтээлийг нэгтгэн харвал эх буриад хэл нь тухайн хүний, улсын, үндэстний амьд, тусгаар тогтнон орших амин сүнс нь болж байгаа тухай бахархам сэтгэлийн дуулал болж чадсан байна.

II. Туурвил зүй ба Буриадын яруу найраг

Дорно дахины уран зохиол, яруу найргийн уламжлалд хайртай дотны, итгэлт хүндээ хандсан, түүндээ хэлсэн нандин үг, хүсэл сэтгэлээ ямар нэгэн зүйл (*амьтай амьгүй, бодитой хийсвэр, тодорхой, тодорхой бус*)-д дайж хэлсэн өгүүлэмж чухал байрыг эзэлсээр иржээ. Жишээ нь: Галидасын “Үүлэн зардас”-ыг хэлж болно.

*...Хувьтай чи, бэлэвсэн бус, чиний нөхрийн сайн нөхөр үүл
Чамд түүний сэтгэлийн үгийг уламжлах гэж ирснийг тань!
Гэргийн сүлжсэн гэзгийг нөхрөөр нь тайлуулах гэж
Аянгын дуугаар аянчныг шавдагч үүл би байна гээрэй,*

*Аяа, наснаа төгөлдөр! Бусдын тус бүтээвэл өөрийн тус бүтнэ.
Миний үг сонсон дамжуулахдаа, амраг чинь Рамын ууланд
Чамаас хагацан, амьд бөгөөд, чиний мэндийг асууна гээ*

Тэр үг хагацах зовлонд учрагсдын ам нээж асуудаг үг...”

[Галидас “Үүлэн зардас”]

Ийм маягийн зохиол бүтээлийн ерөнхий өгүүлэмж монгол уран зохиолд эртнээс нөлөөлсний баталгаа нь монголын олон үндэстний ард түмэн өөрсдөийм өгүүлэмж бүхий олон бүтээл туурвисан байна. Өөрөөр хэлбэл бусдад хэлэх үг, дэлгэх сэтгэл санаагаа ямар нэгэн зүйлд дайж, зуучлуулсан өгүүлэмж бүхий зохиол бичих уламжлал өнөө үеийг хүртэл тасралтгүй үргэлжилсээр байгаа болно.

Таанын үнэрт салхи чи

Талын дээгүүр өнгөрөхдөө

Танхилхонгор түүнд минь

Танил дууг минь дамжуулаарай

Сэвшээ зөөлөн салхи чи

Сэлүүн талаар аялахдаа

Сэргэлэн хонгор түүнд минь

Сэтгэлийн үгийг минь шивнээрэй”

Үелзүүр зөөлөн салхи чи

Үүлсийг хөөн наадахдаа

Үнэнч хонгор бүсгүйг минь

Үнсэн таалан илбээрэй

Хангайн цэнхэр салхи чи

Хаврын шувуудтай хамтраад

Хайрт намайг очино оо гээд

Хайртай түүнд минь дамжуулаарай...

[Адарсүрэн]

Энэ бол монголын уран зохиолын нэгэн жишээ. Тэгвэл буриадын яруу найрагч Намжилов Чимит-Рэгзэний “Захьяа” хэмээх нэгэн бүтээлийг сонгон үзье.

Хэнтийн нуруунаа эхи татаһан Тэрэлжин гол

Хэды холыг зорижо гараһанаа мэдээ бол –

Аласай аласта золгоһон Байгал гэдэг үбгэндэ

Абаашажа хүргыи миний халуун амар мэндэ.

Торгон хээтэй тунгалаг хайхан урасхалдаа

Толидол адляар дүрьем абыи гэжэ гуйналби.

Толгой нюсэгэн, хүхюун дорюун – энэл зандаа

Тоонто нютагаа хүрэхэн шэнги болохолби.

Адуун хүрэгхөө али дуратайгаа барижа унаад,

Алтай, Хангайһаа аяар Дорнод руу гүйлгэнэ гээрэй.

Анда нүхэдөөрөө аялга нишлэн ханхинуулаад,

Айраг тарагайнь хайхан дээжые амасана гээрэй.

Мүнхэ сагаан Одхон Тэнгэри өөдэ абирһаар,

Мүнгэн хюруудань ханишагаа дайруулаа гээрэй.

Сайн-Шандын, Үмэнэ-Гобиин хуурай халхинһаа

Сайбар шарайнь хүрилэн харлаа гээрэй.

Холын дайдада өөрын хүн шэнги болоод,

Хотогор наалагар нуугаашые хаа, уйдана гээрэ.

Зүрхэндөө дүтын аха дүүнэр, зон голоо

Зүүдэндээ хаража, урмашан баясана гээрэй.

[Алтан модоной баяр, 2016, 137-р т.].

Хэнтийн нуруунаас эх татсан Тэрэлжийн гол

Хэдий холыг зорьж гарснаа мэдсэн бол

Алсын алсад золгосон Байгал гэдэг өвгөнд

Аваачиж хүргэнэ үү миний халуун амар мэнд

Торгон хээтэй тунгалаг сайхан урсгалдаа

Толидол адилаар дүрийг минь аваач гуйнам би

Толгой нүцгэн хөхүүн дориун энэ л зандаа


Тоонот нутгаа хүрсэн шиг болноо би

*Адуун сүргээсээ аль дуртайгаа барьж унаад
 Алтай Хангайгаас алс Дорнод руу гүйлгэнэ гээрэй
 Анд нөхдөөрөө аялга нийлэн хангинуулаад
 Айраг тарагны сайхан дээжийг амсана гээрэй*


*Мөнх цагаан Отгон тэнгэрийн өөд авирсаар
 Мөнгөн хярууд нь санчигаа дайруулаа гээрэй
 Сайншиандын, Өмнөговийн хуурай салхинаас
 Сайвар царай нь хурлэн харлаа гээрэй*

*Холын дайдад өөрийн хүн шиг болоод
 Хотгор налгар суугаа ч уйдна гээрэй
 Зүрхэндээ дөт ах дүү нар зон олноо
 Зүүдэндээ харж урамшин баясана гээрэй*

Өөрийн дотоод санаа сэтгэл, хэлье гэсэн үгээ ийнхүү ямар нэг зүйлд дайж буй тухай өгүүлэмжийг ажиглахад туурвил зүйн сэтгэлгээний өвөрмөц сэтгэмж ажиглагддаг. Юуны өмнө ийм өгүүлэмж нь ЗОХИОЛЧ – ЗОХИОЛ – УНШИГЧ гурвын холбоо хийгээд эл гурвыг хооронд зуучилж байгаа meditation(media) – хэмээх зүйлийн тухай авч үзэх ёстой. Ийн үзвэл аливаа уран бүтээл нь ЗУУЧЛУУЛАГЧ – ЗУУЧЛАГЧ – ХАРИЛЦАА ХОЛБОО – гэсэн загвартай байдаг. Үүнийг Америкийн утга зохиолын онол судлаач М.Н. Abrams “Зохиолч – Зохиол – Уншигч – Ертөнц” гэсэн дөрвөн зүйлээс уран зохиолын тогтолцоо бүрдэнэ” [Abrams] гэж үзээд дараах загварыг бүтээжээ.



Харин бид ЗОХИОЛЧ – ЗОХИОЛ – УНШИГЧ гурвын холбоо харилцаанд дараах загварыг санал болгож байгаа юм.



Намжилов Чимит-Рэгзэний “Захьяа” шүлгийг эл загвартаа буулган үзвэл: зохиолчийн үзэл хандлага буюу зуучлуулах гэсэн зүйл нь: *Төрсөн нутагтаа тэмүүлсэн их сэтгэл* болно. *Төрсөн нутаг, эцэг эх, садан төрөл, унасан газар, угаасан ус, Байгал далай, мойл, цөцгий, талх ...*гээд өөрийн гэсэн унаган заяасан бүх зүйлс нь хуран хурсаар амьдрал аж төрөл, ахуй байдлын туршлага хуримтлуулах тусам, аж төрөх ухаарал нэмэгдэх бүрд, нас ахих тутам дотор сэтгэлд нь багтахаяа больж ирсэн тэрхэн үе болно. Ийнхүү сэтгэлд хурсан тэр их зүйл нь нэгэн цагт, нэгэн агшинд задран гарахдаа заавал зуучлагчаар дамждаг ажээ. Намжилов Чимит-Рэгзэн гуайн хувьд энэ их сэтгэлээ шүлэг яруу найргаар, бүр нарийвчилбал “Хэнтийн нуруунаас эх татсан Тэрэлжийн гол”-ыг сонгон авсан байна. Тэрэлжийн голд яг л Галидас өөрийн амрагтаа хэлэх үгээ үүлэнд дайж хэлсэн шиг бүхий л сэтгэл санаа, зүс царай юугаа бүгдийг нь хэлж “дотор”-оо онгойлгож чаджээ. Нэгэнт зуучлуулагчийн “ачаа, тээш”-ийг хүлээн авсан зуучлагч маань үүргээ биелүүлэхээр буюу “Харилцаа холбоо” тогтоохоор авч одлоо. Уран бүтээлийг ийнхүү media-ийн үүднээс томьёолж, өгүүлэмжийн туурвил зүйн сэтгэлгээний хэлбэрийг тодотгох нь өрнийн утга зохиолын нэгэн үнэт зүйл болсон ажээ. Тэд туурвил зүйн сэт-

гэлгээний олон арга барилаас чухам Media-хэлбэрийг сонгон авсан үндэслэлээ “ийм хэлбэрээр илэрсэн бүтээлийн ерөнхий агуулгад дотоодын сэтгэлийн хандлага тод, учир зүй, учир шалтгааны үндэслэл, үнэлэмж нь ил байдаг” учраас хэмээн тайлбарлаж, улмаар Media агуулгатай бүтээл нь:

1. Тухайн бүтээлийн мөн чанарыг зөв танин мэдэх, ойлгох, ухаарахад нэгэн хөтлөгч нь болж өгнө. Энэ үүднээсээ сургалт, хэрэглээний хүрээнд тодорхой ач холбогдолтой

2. Тухайн туурвигчийн уран бүтээлийн туурвил зүй, уран сайхны гоо зүйн сэтгэлгээний онцлог, залгамж чанар, уламжлалт шинж, шинэчлэгч чанар нь тодорно.

3. Уран бүтээлийн тодорхой нэгэн орчин, үзэгдлийг зөвхөн нэг талаас үнэлэх дүгнэх бус, олон тал онцлогоос нь харах боломжийг олгодог давуу талтай

хэмээн үзжээ. Тэгэхээр эндээс бид олон зүйлийг өгүүлэх бололцоотой ч гэсэн, ямар ч атугай буриадын яруу найргийн туурвил зүйн сэтгэлгээний ололт нь дэлхийн уран зохиолын өв туршлага, үнэт зүйлтэй алхаа нэг, хамт зэрэгцээ байгаа нь ололт юм гэж үзэх бүрэн үндэстэй.

Ш. Гүн ухаан ба Буриадын яруу найраг

Аливаа бүтээлийн бичгийн зохиол болсон эсэх нэгэн шалгуур нь тухайн бүтээл дэх гүн ухааны шинж болно. Ялангуяа яруу найраг уянгын зохиол нь уянгалаг, урсам ялгуун байх нь зүйтэй ч түүнээс дутуугүй гүн, төв, нарийн чамбай байх ёстой. Энэ шалгуурт нийцсэн шүлэг яруу найраг Буриадын уран зохиолд бий. Тухайлбал Б. Галсансүхийн “Чингис хаан”, Баларьева Туяна “Жаргал хаанаас эхтэй юм?”, Гомбожапов Тимур “Хун шубууд”, Гомбоин Ирина “Буряад хүгжэм”, Баяр Дугаровын “Би дурлалын тухай” зэрэг олон бүтээлийг дурдаж болно. Б. Галсансүх “Чингис хаан” шүлэгтээ:

Нэг жэлэй арбан жэл шэнги урдахыг

Нэгэл үглөө нэрихэдээ мэдэбэб.

Нэгэ наһанда мянган жэлэй үйлэ бүтээжэ болохыг

Нэгэл жэлэй туршада ойлгожо өөртөө мэдэрбэб.

[Алтан модоной баяр, 2016, 9-р тал]

Нэг жил арван жил шиг урсахыг

Нэг л өглөө сэрэхдээ мэдэв ээ

Нэг насанд мянган жилийн үйл бүтээж болохыг

Нэг л жилийн турш ойлгож өөртөө мэдрэв ээ

Шүлгийг хэлбэрийн талаас нь харвал маш цомхон. Ердөө дөрөвхөн мөр шүлэг. Гэтэл эл дөрвөн мөрөнд ямар гүн санаа, яасан баялаг агуулга багтаж байна вэ? Драмын аргаар бичсэн шүлэг учраас шүлэгт Чингис хаан гэсэн нэг ч үг орсонгүй. Тэгэхээр драмын арга гэдэг ньгол дүрээ тодруулахдаа түүний дүр төрхийг дурдан дүрслэх биш түүнтэй холбоотой үйл хэргийг өгүүлэх байдлаар дүрээ тодруулдаг арга болно. Чухам “Нэг насандаа мянган жилийн үйл бүтээсэн хүн хэн билээ?” хэмээх асуулт руу хөтлөн аваачиж, улмаар “Ийм агуу хүн энэ орчлон ертөнц дээр цор ганц Чингис хаан юм” хэмээх хариултыг сэтгэл дотроо бахархан, тэгэхдээ ухаарч ойлгож мэдэрч байна.

Тэгвэл Баларьева Туяна “Жаргал хаанаас эхтэй юм?” шүлэгтээ экзистенциал санаа буюу хүний оршихуйн утга учрын агуулгыг илэрхийлсэн байдаг. Экзистенциалистууд “Хүн бодитой, тодорхой оршин байхуй гэгч дээр оршдог” гэж үзэх ажээ. Энэхүү оршин байхуй гэдэг нь тухайн хүний ухамсрын гадна хүнийг хүрээлэн оршдог зүйлсийн нэгдсэн тогтолцоо гэнэ. Хүн гэгч амьтан баярлах, хөөрөх, бахархах, онгирах, хайрлах, дурлах, уурлах, гомдох, гутрах, гуних, ховдоглох, залхуурах, хуурах, тоглох, ажиллах, хөдөлмөрлөх гэх мэт оршихуйн олон элемент буюу экзистенц гэдэг зүйлийн нийлбэр дээр оршдог ба эдгээр элементүүд нэгдэн нийлж нэгэн бүтэн тогтолцоог бүрдүүлдэг гэнэ. Экзистенциалистуудын энэ үзэл “Жаргал хаанаас эхтэй юм?” шүлэгт ийн тусчээ.

Жаргал хаанаһаа эхитэй юм?

Булагай сарюун уһанһаа,

Буряадхан дуунай аялганаа,

Булашын амттай үнэрһөө

Бууралхан ээжын сэдхэлһээ.

Жаргалтай харгы – тоонтоһоо,

Жаргалай эхин – ээжы абаһаа.

Жаргал хаанаас эхитэй юм?

Нютагай хара шоройһоо,

Нангин дуранай хүсэнһөө,

Жаргал хаанаас эхтэй юм?

Булагийн сарюун уснаас

Буриад дууны аялгаас

Булачийн амттай үнэрнээс

Бууралхан ээжийн сэтгэлээс

Жаргалтай зам – тоонтоһоо

Жаргалын эхин – ээж ааваас

Жаргал хаанаас эхтэй юм?

Нутгийн хар шорооноос

Нангин хайрын хүссэнээс

*Нооһоор нэхэн бээлэйһээ,
Нялха нарайн энээдэнһээ.*

*Жаргалтай харгы – тоонтоһоо,
Жаргалай эхин – ээжы абаһаа.*

*Жаргал хаанаһаа эхтэй юм?
Эртын хабарай горхонһоо,
Эмнигэй хурдан гүйдэлһөө
Үнжэгэн сагаан хүнһөө,
Үбгэд хүгшэдэй үрээлһээ.*

*Жаргалтай харгы – тоонтоһоо,
Жаргалай эхин – ээжы абаһаа.*

[Алтан модоной баяр, 2016, 24-р т.].

*Ноосоор нэхсэн бээлийнээс
Нялх нярайн инээднээс*

*Жаргалтай зам – тоонотоос
Жаргалын эхин – ээж ааваас*

*Жаргал хаанаас эхтэй юм?
Эрт хаврын горхиноос
Эмнэгийн хурдан гүйдлээс
Өрөмний цагаан сүүнээс
Өвгөд хөгшдийн үрээлээс*

*Жаргалтай зам – тоонотоос
Жаргалын эхин – ээж ааваас*

Шүлэгт ийнхүү аз жаргалыг бүрдүүлэгч элемент буюу экзистенц нь *Булагай сарюун ус, Буриад дууны аялга, Булачийн амттай үнэр, Буурал ээжийн сэтгэл, Нутгийн хар шороо, Нандин хайр, Ноосоор нэхсэн бээлий, Нялх нярайн инээд, Эрт хаврын горхи, Эмнэгийн хурдын гүйдэл, Өрөмний цагаан сүү, Өвгөд хөгшдийн үрээл* ... эд бүгдийг нийлбэр болж байна. Энэ бүхнээ мэдрэн, хүртэн байх нь жинхэнэ аз жаргалтай байгаагийн илрэл болж байна. Хэрэв тогтолцоог бүрдүүлэгч эдгээр элементийн аль нэг нь л үгүй болох юм уу, сэвтэж, гэмтэж эвдрэх аваас, энэхүү тогтолцоо эвдэрч, улмаар оршин байх, амьдрах ямар ч учир утгагүй болдог ажээ. Ямар ч атугай буриад үндэстний оршихуйн үнэт зүйл нь аж төрөл ахуй амьдралыг нь цоглоон бий болгосон “*Жаргалын зам – тоонот, Жаргалын эхин ээж аав*”-тай нь холбоотой, энэ үнэт зүйлээс эхлэл үүсэлтэй болохыг дүрслэн өгүүлсэн байна.

Гомбожапов Тимур “Хун шубууд” шүлэгт нэгэн сонирхолтой бодомж гаргасан байдаг. Тухайлбал:

*Далайн саанаһаа бууһан
Дангина һайхан шубууд,
Эртын домог һануулан,
Элинсэгэйм эхи дурдуулба гүт?
Саһан шэнгээр сайбалзаад,
Сагаан һанаа уряалба.
Дуран шэнгээр үзэгдөөд
Дуунай аялга түрүүлбэ.
Сэдьхэлни гэнтэ далижаад,
Сэнхир огторгой руу дүүлээлби.
Уг гарбални дуудаад,
Үлгэрэйн орон руу нишдээлби.*

[Алтан модоной баяр, 2016, 59-р т.].

*Далайн цаанаас буусан
Дагина сайхан шубууд
Эртний домог сануулан
Элэнцэгийн минь эхийг дурдуулав уу?
Цасан шигээр цайвалзаад
Цагаан санаа уриалав
Дур (хайр) шиг үзэгдээд
Дууны аялгуу төрүүлэв
Сэтгэл минь гэнэт дальжаад
Цэнхэр огторгуй руу дүүлээ
Уг гарвал минь дуудаад
Үлгэрийн орон руу нислээ*

хэмээн дүрсэлсэн “Хун шубууд” шүлэгт жинхэнэ үнэн бодит ертөнцийн эсрэг бие хүн өөрийнхөө дотоод сэтгэл, оюун ухаандаа бий болгосон дэврүүн сайхан хүслэнгийнхээ ертөнцийг сөргүүлж тавих байдлаар өөрийнхөө үзэл баримтлалыг дэвшүүлсэн юм. Нэг харахад гунигтай ч юм шиг, нөгөө бодоход дэврүүн ч юм шиг сэтгэл зүйг бий болгож чадаж байгаа нь эл шүлгийн гүн ухааны шинжийн илэрхийлэл болж байна.

Ийн дүгнэвэл гүн ухааны аяс, үнэлэмж бүхий буриадын яруу найраг нь амьдралын утга учрын эргэцүүлсэн, хүн байхын мөн чанарыг ухааруулсан, үндэстэн угсаатныхаа уламжлал шинэчлэл, хүсэл мөрөөдөл, оршихуйн асуудлыг тайлбарлан таниулсан шинжтэй ажээ.

IV. Угсаатан ба Буриадын яруу найраг

Монголын уран зохиол судлаач, эрдэмтэн Ч. Билигсайхан “Ухаарахуй” хэмээх утга зохиолын онолын бүтээлдээ: «Монгол сонгомол уран зохиол нь өөрийн үзэл санаа илэрхийллийн тодорхой чиглэл хандлага урлахуйн нарийн арга барил, бичлэгийн үнэн магадтай баримт түүх, заримдаа илэрхий үнэн хэрэг явдлаас юмуу түүний “цуурай”-наас төрсөн шүлэг дуу, битүү далд утгатай домог хуучаар орлуулан гаргаж, эрхилэн хэлхэх замаар гагцхүү болсон явдал үнэн түүхийг үзүүлэх зарчимд хатуу захирагдаж иржээ. Монгол угийн бичиг хөтлөх ёс жаяг нь Монгол түүхэн уран зохиолын анхны арга найруулга болж өгчээ. “Монголын нууц товчоон”-ы эхний хэсэг буюу Тэмүжиний уг гаралын тухай өгүүлэмж нь, тэр угийн бичиг хөтлөж эхлэх үеийн бүтээл гэдэг нь баталгаа шаардахгүй үнэн бололтой» [Билигсайхан, 2003, 149-р т.] хэмээн тодорхойлсон байдаг. Үнэхээр монгол угсаатан үндэстнүүд өөрсдийн угсаа гарлын талаарх үнэн магадтай бодит мэдлэг мэдээллээ, нутаг усныхаа үүх түүхээ, нүүдэл суудлынхаа учир шалтгааныг ямагт бичиг зохиол,

аман түүх домгоороо уламжлуулан залгамжлуулж, үр хүүхэд өсвөр хойчоо угсаатан үндэстнийхээ түүхээр сурган хүмүүжүүлж ирсэн билээ. Амьдарч тэмцэж, туулж өнгөрүүлсэн үнэн түүхээ уран зохиолынхоо гол дүр болгон үзүүлж, улмаар үндэсний соёлын үнэт зүйл болгон төлөвшүүлж чадсан нь монгол бичгийн зохиолын туурвил зүйн сэтгэлгээний хамгийн гол шинжийн нэг нь болдог билээ. Чухам энэ талаараа монголын олон үндэстний дотор буриадууд гойд ялгардаг. “Хорь түмэд Хорилардай мэргэний домог”, “Буриадын угийн бичиг” тэргүүт алс холын үнэт соёлынхоо өвийг уламжлан залгамжилсан олон үлэг зохиол ХХ зуунд гарсан байна. Үүнд Чимитов Гунгаагийн “Монгол туургатанай дуун”, Б. Бадараа “Миний Шэнэхээн”, Балжинимаев Дашдондог “Буряад Монгол арадни” Б. Зийдэгмаа “Буряад зомди”, Гомбоин Ирина “Гүн талын шибнээн”, Г. Батсүх “Энэ Буряад зон” зэрэг олон бүтээлийг хэлж болно. “Миний Шэнэхээн”-д

*Шэлүүхэн малгай үмдэжэ, түрүү бариһан,
Нэхы дээл дээрээ шонын арһан даха хэдэржэ,
Утаһатай гуталдаа ямаан пэнише углажа
Шаргадаа мори хүллэһэн,
Саһатай үбэл најсардаггүй
Сэнгүүхэн зантай миний Шэнэхээн Буряад!*

*Задагай доро наранда халажа,
самнажа барилдаһан
Зосоом тэнигэр гэжэ дуулажа нарьяһан
Хүдэр мүнгэн хутага
Шанхай дурдан бүхэдээ зүүжэ,
Хүгшэд үбгэдэй урда тээ ёһотой
номтойш ябаһан
монголын нэг угсаа
мини Шэнэхээн!*

*Намдаг ноёноймнай амбан ноёнһоо олоһон
Голой гурбан тохойтой,
гоёл нутаг Шэнэхээн
Шэртэхэдэл зохид
хадануудай шэлэл нутаг Шэнэхээн
Жэлдээ тахил обоотой,
жэсгтэй гоёл Шэнэхээн!
Наадан нарьян олонтой,
намжар гоёл Шэнэхээн дээр
наян жэл нутаглаһан намтар түүхэтэй
Миний Шэнэхээн Буряад!*

[Алтан модоной баяр, 2016, 31-р т.] хэмээн өгүүлжээ.

Шүлгийн эхэнд Шэнэхээн буриадуудын угсаатны имиж дүр төрх, ялгагдах онцлогийн талаар гол мэдээллээ өгч байна. Байгал цаг уурын орчин нөхцөл, үүндээ дасан зохицсон хувцас хэрэглэл өмсч зүүдэг, өөрсдийн гэсэн заншил дадгалтай болсон зэрэг угсаатныхаа үндсэн танилцуулгыг хэлж байна. Харин шүлгийн дунд хэсэгт өөрсдийн угсаа гарлын талаар, хэрхэн нутагшин идээшсэн талаараа ярьж, унаган заншил ёс, хэв байдлынхаа талаар дүрсэлжээ. Чухам ингэж л үнэн магадтайн үүднээс өөрсдийн үүх түүхээ дүрслэн уламжлуулдаг байна. Тэгвэл Балжинимаев Дашдондог “Буряад Монгол арадни” шүлэгтээ ийн өгүүлж байна.

*Бүртэ-шоно эсэгэтэй, Гуа-Марал эхэтэй,
Буурал сагаан түүхэтэй буряад монголиуд гээшэбди.
Хорилартай мэргэней Баргужин-гуа хатанһаа
Байгал шадар тэнжэһэн барга-буриадууд гээшэбди.*

*Алан-Гуа эхэмнай, Ара-Монгол нутагнай,
Хун шубуун гарбалнай, хуһан модон сэргэмнай,
Байгал номин далаймнай, Баргужин-Гүхэм нутагнай,
Саяан үндэр ууламнай, заяан ехэ Монголнай!*

*Хамаг Монголые хамталһан Хаан Чингисэй үринэр
Хангай, Хэнтэй, Саяандаа хаяа хадхан нуунал даа.
Онон, Хэрлэн голнууднай олон арадые тэнжээгээ,
«Алтаргымнай» найр наадан аха дүүнэрые нүхэсүүлээ.
[Алтан модоной баяр, 2016, 34-р тал].*

*Шилүүсэн малгай өмсөж, түрүү барьсан
Нэхий дээл дээрээ чонын арьсан дах хөдөрч
Утастай гуталдаа ямаан дах углаж
Чаргадаа морь хүллэсэн
Цастай өвөл даардаггүй
Цэнгүүхэн зантай миний Шэнэхээн Буриад*

*Задгайд наранд халж,
самнаж, барилдсан
Зосоом тэнэгэр гэж дуулж наргисан
Хүдэр мөнгөн хутга
Шанх дурдан бүсэндээ зүүж
Хөгшид өвгөдийн урьдын ёстой
номтой явсан
Монголын нэг угсаа
Миний Шэнэхээн*

*Намдаг ноёныхоо амбан ноёноос олсон
Голын гурван тохойтой
гоёл нутаг Шэнэхээн
Ширтэхэд зохисон
хадтай шилэл нутаг Шэнэхээн
Жилдээ тахил овоотой,
жигтэй гоёл Шэнэхээн
Наадам наргиан олонтой
намжар гоёл Шэнэхээн дээрээ
Наян жил нутагласан намтар түүхтэй
Миний Шэнэхээн Буриад*

*Бөртө чоно эцэгтэй Гуа марал эхтэй
Буурал сагаан түүхтэй буриад монголчууд гээч бид
Хорилардай мэргэний Баргужин гоо хатнаас
Байгал шадар өссөн барга буриадууд гээч бид*

*Алан гуа эхтэй, Ар монгол нутагтай
Хун шувуун гарвалтай, хус модон шонтой
Байгал номин далайтай Баргужин Түхэм нутагтай
Саяан өндөр уултай, заяа их Монголоо*

*Хамаг Монголыг байгуулсан Хаан Чингисийн үрс
Хангай Хэнтий Саяандаа хаяа хатган суунал даа
Онон, Хэрлэн голууд олон ардыг өсгөсөн
Алтаргана найр наадамдаа ах дүү нартайгаа дотносоноо...*

Эл шүлгийн гол онцлог нь буриад үндэстний гарал үүсэл, туулж өнгөрүүлсэн үүх түүх, бүтээн бий болгосон соёл, наадам ахан дүүс зон олонтойгоо эв найртай байхын учир, бэлгэдлийг дамжуулж байгаад оршино. Тэгвэл Б. Зийдэгмаагийн “Буряад зомди”-д огт өөр үзэл санааг дэвшүүлсэн байна. Шүлэгт:

*Буряад лэ хүн мүн хаа,
Номдо ханаар хураха ёһотойш.
Буряад лэ хүн мүн хаа,
ажалша, сэбэриэ байха ёһотойш.
Буряад лэ хүн мүн хаа,
зүлгы хүндэмүүшэ байха ёһотойш.
Буряад лэ хүн мүн хаа,
үнэншэ, шударгуу байха ёһотойш.
Буряад лэ хүн мүн хаа,
муухай үгэ хэлэхэ ёһогүйш.
Буряад лэ хүн мүн хаа,
муу үйлэ хэхэ ёһогүйш.
Буряад лэ хүн мүн хаа,
буриадайнгаа нэрые хухалха ёһогүйш.
Буряад лэ хүн мүн хаа,
хэлэ, ёһоо мартаха ёһогүйш.
...Нээрээл би буряад хүнби.
Нэрээ бодожо ябаха ёһотойб.
Нэрэмни ганса минш нэрэ бэшэ
Нийтэ буряадаар обогложо ябахалби.
Үнэн даа, бидэ бултаараа буряад зомди.
Үргэн дэлхэйдэ заяа хуби нэгтэйбди.
Гаар ябадалгүй, хараалай үгэгүй,
Гайн заяатай буряад зомди.
Аригуун дээдэ изагууртай бэлэйбди,
Абьяас бэлиг ехэтэй бэлэйбди.
Ухаан бодолоор харуул бэлэйбди,
Удам ёһоор шанга бэлэйбди.
Буряадайнгаа нэрые үндэртэ үргэе,
Бултанһаа үлүү амжалта гаргая.
Эб, нэгэдэл хайтай байя,
Эрэнхэн дэлхэйдэ алдараа мандуулая!*

[Алтан модоной баяр, 2016, 36-р т.]

*Буриад хүн мөн бол
номд сайнаар сурах ёстой
Буриад хүн мөн бол
ажилч цэвэр байх ёстой
Буриад хүн мөн бол
ээлдэг найрсаг байх ёстой
Буриад хүн мөн бол
үнэнч шударга байх ёстой
Буриад хүн мөн бол
муухай үг хэлэх ёсгүй
Буриад хүн мөн бол
муу үйл хийх ёсгүй
Буриад хүн мөн бол
буриад нэрээ хугалах ёсгүй
Буриад хүн мөн бол хэл
хэл, ёсоо мартах ёсгүй
Нээрээ л би буряад хүн би
Нэрээ бодож явах ёстой
Нэр минь ганц миний нэр биш
Нийт буриадаар овоглож явдаг
Үнэн дээ бид бүгд буриад зон
Өргөн дэлхийд заяа хувь нэгтэй
Саар явдалгүй хараал үггүй
Сайн заяатай буриад зон
Ариун дээд язгууртай билээ бид
Абьяас билэг ихтэй билээ бид
Ухаан бодлоор саруул билээ бид
Удам ёсоор чанга билээ бид
Буриадынхаа нэрийг өндөрт өргөе
Бусдаас илүү амжилт гаргая
Эв нэгэдэл сайтай байя
Эрээн дэлхийд алдараа мандууля*

хэмээн дүрсэлж байна. Өнгөц харахад уриа лоозон, хоосон тунхаг мэт байгаа ч огт тийм биш юм. Энэ бол бие хүний нийгэмд эзлэх байр суурь хийгээд өөрийн –Би-г ухамсарласан сэтгэлгээ юм. Чухам ийм сэтгэлгээ монголын уран зохиолд эртнээс төлөвшиж ирсэн юм. XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн монголын төр нийгэм соёлын нэрт зүтгэлтэн С.Лувсандондов ийм нэгэн шүлэг бичжээ: *Эгэл хүн бүр / Ая барих эрдэмгүй / Эзэн хүн бүр / Эгнэгт манлайлах журамтай* [Шүлэгч..., 1989, 79-р т.] гэжээ. Энэ бол ёс журмыг үл зөрчих тухай амьдралын сургаал болно. Мөн тэрээр “Буга намнахуй” хэмээх шүлэгтээ:

*Авын олон нөхөд минь
Амар тайвныг эвдэн давхиад*

Аглаг ойд ороход минь
Аалзны шүлс шиг хоолой торлов
Буутай нь жим даган гэтээж
Буугүй нь дөрөө даврин үргээв
Бугын эвэр сэрхийх хоромд
Буун дуу тасхийн хадав
Арван салаагаа сэрвээ дээрээ үүрэн
Аварга заан шиг буга тэрийв
Аяа нөхөд минь

Буга боловч эврээ хайрладаг ахул
Бусчир явдлаа тэвчиж нэрээ хайрлалтай

[Шүлэгч..., 1989, 82-р т.] гэсэн байдаг. Буга хүртэл үхэхдээ эврээ хайрладаг өгүүлэмжээс хэн боловч өөрийн нэрээ буга эврээ хайрлах мэт хамгаалж явах ёстой гэсэн эргэцүүлэл рүү дэвшүүлэн урлажээ. Ийн үзвэл “Буряад зомди” шүлэг нь хоосон уриа тунхаг бус эрт ба эдүгээ үеийн монголяруу найргийн уламжлал шинэчлэлийн амьд холбоо болох нь илэрхий байна. Тэгвэл Г. Батсүхийн “Энэ Буряад зон” шүлгийг үзье.

Энэ буриад зон
Домогой найхан Алан-Гуае
Добу мэргэндэ мордохуулаад,
Боржогон халхын нагаса гүүлэжэ,
Бохирхо забгүй ябахан гэдэг.

Энэ буриад зон
Нагасын туһа зээдээ гэлсээд,
Хаан Чингэстээ хабсархан гэдэг.
Хамаг ехэ гүрэнэй
Хана боложо ябахан гэдэг.

Энэ буриад зон
Харайжа ерэнэн хариинхидта
Бабжа-Баатараа ябуулхан гэдэг.
Харбах намнахын шидээр
Хатуу харюу бариһан гэдэг.

Энэ буриад зон
Бадан Тураахин баабайгаа
Хаан Пётрто эльгээһэн гэдэг.
Байгал шадарай зондоо
Ханы зарлиг асаруулһан гэдэг.

Энэ буриад зон
Саһатын сагаан орондо
Агбаан хамбаяа ябуулһан гэдэг.
Санид номой ушарта
Сагһаа эртэ гэгээрһэн гэдэг.

Энэ буриад зон
Зүниэ мэргэн Молон багшаар
Зөөдэл, һуудалаа зуруулһан гэдэг,
Зүб, буру, түүхэ төөрийгөө
Шулуундаа бэшээд хадгалһан гэдэг.

[Алтан модоной баяр, 2016, 69-р т.].

Энэ буриад зон
Домгийн сайхан Алан гуаг
Добу мэргэндэ мордуулаад
Боржгон халхын нагац гэжээ
Бохирох завгүй явсан гэдэг

Энэ буриад зон
Нагацын тус зээдээ гэлцээд
Хаан Чингистээ хавсарсан гэдэг
Хамаг их гүрний
Хана болжэ явсан гэдэг

Энэ буриад зон
Харайжэ ирсэн харийнхад
Бабжа Баатараа явуулсан гэдэг
Харвах намнахын шидээр
Хатуу хариу барьсан гэдэг

Энэ буриад зон
Бадан Тураахин баавайгаа
Хаан Пётрт илгээсэн гэдэг
Байгал шадар зондоо
Хааны зарлиг авчруулсан гэдэг

Энэ буриад зон
Цастын цагаан орондоо
Агваан хамбаа явуулсан гэдэг
Цанид номын учирт
Цагаас эрт гэгээрсэн гэдэг

Энэ буриад зон
Зөнч мэргэн Молон багшаар
Зүүдэл суудлаа зуруулсан гэдэг
Зөв буруу түүх төөргөө
Чулуундаа бичээд хадгалсан гэдэг

гэх зэргээр түүхээ сударлажээ. Энэ мэт дээр дурьдсанчлан аливаа соёлд үнэт зүйлийн өөрийн гэсэн шинэ (утга зүйн) хандлагууд үүсэнбий болж, цэцэглэн хөгжсөөр байдаг нь буриад үндэстний орчин үеийн шинэ уран зохиолд илэрхий харагдаж байна. Эл судалгааны өгүүлэл нь тухайн үндэстний оршихуйн асуудлын гол хүчин зүйл болсон үндэстний соёлын үнэт зүйлийн тусгалын илэрсэн байдлыг уралагийн тодорхой бүтээлийн жишээн дээр авч үзсэн ба ийн судалсны гол учир нь уламжлалт соёлд нөлөөлөх чухал хандлагууд үгүй болохоос сэргийлж, харьцуулсан уран зохиолын жишээгээр дамжуулан өвлүүлэх, сэргээх, дэлгэрүүлэх боломжийг олгоход нэмэр төдий болгоход оршино.

Ном зүй

Алтан модоной баяр. Улаан-Үдэ, 2016.

Билигсайхан Ч. Ухаарахуй. Улаанбаатар, 2003.

Болд Л. Монголд гурван үнэгүй зүйлийн нэг нь эх хэл болчихоод байна. URL: <http://ikon.mn/n/1a3v>.

Цэдэндорж М.. Бурхан буудайн хөх салхи. Улаанбаатар, 1988.

Чоймаа Ш. Хэлний экологи // Эх хэл бичиг. Улаанбаатар, 2012.

Шүлэгч Лувсандондовын бүтээл // Дурсгалт бичгийн чуулган. Улаанбаатар, 1989.

Abrams M. Y. URL: https://en.wikipedia.org/wiki/M._H._Abrams.